



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХУВИЙН ХЭВШИЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД “АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧИЛГА-2014” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Уралдааны зорилго:

Жил бүрийн арванхоёрдугаар сарын 9-ний өдрийг НҮБ-аас Авлигын эсрэг олон улсын өдөр хэмээн тунхагласан бөгөөд энэ өдрийг угтан Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний сайн туршлагыг тодруулан шалгаруулдаг уламжлалтай. Энэ жил **“АВЛИГААС АНГИД, САЙН ЗАСАГЛАЛЫН САЙН САНААЧИЛГА-2014”** уралдааныг улсын хэмжээнд нийт төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын дунд зарлаж байна.

Хээл хахууль, хүнд суртлаас ангид үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэж байгаа, сайн засаглалыг салбар бүртээ, байгууллагын дотооддоо нэвтрүүлж байгаа тэргүүний арга туршлага, санаачилгыг улс орны хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд мэдээлэх, тэдгээрийг урамшуулах, бусад төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад үлгэр дууриал болгоход уралдааны зорилго оршино.

Уралдааны хугацаа:

Уралдаанд оролцох төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийг дуустал хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар танилцуулга мэдээллээ 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

Шалгуур үзүүлэлт:

Уралдаанд оролцогч байгууллага нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна:

- ❖ Авлигаас ангид, сайн засаглалын төлөөх үйлчилгээг бий болгох талаар бодитой ажил төлөвлөж, үр дүнгээ тооцсон байх;
- ❖ Хүнд суртал, чирэгдлийг арилгах, шат дамжлагыг цөөрүүлэх чиглэлээр шинэлэг санал, санаачилга гаргаж, хэрэгжүүлсэн байх;
- ❖ Үйлчилгээний ил тод, нээлттэй орчинг бүрдүүлсэн байх;
- ❖ Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид сайн засаглалын төлөөх үйл ажиллагаа нь үр өгөөжтэй, хүртээмжтэй, нийтийн эрх ашгийг хангасан байх;
- ❖ Үйл ажиллагаа нь өөрийн байгууллага, салбартаа тогтворжиж хэвшсэн бөгөөд бусдад сайн туршлага болгож түгээх боломжтой байх;
- ❖ Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зохих дэмжлэг болж, авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэхэд хувь нэмэр болохуйц байх.

Хэн нэрээ дэвшүүлж болох вэ? Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг хангахуйц байгууллага /төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага/, албан тушаалтан /төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд/ нэр дэвшүүлнэ.

Шагнал урамшуулал:

Уралдааныг зохион байгуулагчдаас бүрдсэн тусгай хороо дээрх 6 шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулалтыг хийж, нийт 7 байгууллага, 2 албан тушаалтныг тодруулна. Шилдэг 7 байгууллага, 2 албан тушаалтанд тусгай шагнал олгох бөгөөд тэднийг улсын хэмжээнд алдаршуулах ажлыг зохион байгуулна. Шагналыг 2014 оны 12 дугаар сарын 9-ний өдөр буюу Авлигын эсрэг олон улсын өдөр гардуулна.

Харилцах хүний нэр, хаяг:

Нэмэлт тодруулга мэдээллийг 70112467 дугаарын утсаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Мөнхжаргалаас лавлана уу. Түүнчлэн munkhjargal@iaac.mn цахим шуудангаар танилцуулга мэдээллээ илгээж болно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР